## ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН ПҮРЭВЖАВЫН ТҮВШИНЖАРГАЛЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

### Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт / | Эхэлсэн, дуусан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго 3.** Байгууллагын захиргаа, хүний нөөц, төсөв санхүүтэй холбоотой арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллах (Хуулиар олгогдсон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх) | | | | | | | |
| Зорилт 1. Байгууллагын захиргаа, хүний нөөцийн эрхэлсэн асуудлын хүрээнд хэрэгжүүлэх зорилт | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ: 3.1.6<br>Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулах, Хариуцлагын гэрээ, төлөвлөгөөний биелэлтийг дээд шатны байгууллагад тайлагнах, нэгж, албан хаагчдын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, төрийн үйлчилгээний албан хаагчдын хөдөлмөрийн гэрээг хугацаанд нь баталгаажуулах, тайлагнах | | | | | | |
| 1. | Дэд арга хэмжээ: Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах | Гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулах, санал авах хуудсаар санал авч баталгуулах | Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр Нийслэлийн Засаг даргаар батлуулсан. | Төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилт, шалгуур үзүүлэлтийн дагуу боловсруулан санал авах хуудсаар санал авч баталгаажуулсан байна. | Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бодлогын зорилтын 3, хуулиар тусгайлан олгогдсон чиг үүрэг 25, хуулиар нийтлэг олгогдсон чиг үүрэг 23, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлийн 7 нийт 58 төсөл арга хэмжээг боловсруулан, НЗДТГ-ын холбогдох нэгжүүдээс санал авч 2024.01.18-ны өдөр Нийслэлийн Засаг даргаар батлуулсан. Байгууллагын төрийн захиргааны болон үйлчилгээний 21 албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хүлээн авч, Хүний нөөцийн ахлах мэргэжилтэн 2024.06.20-ны өдөр С.Учралд актаар хүлээлгэн өгсөн. | 2024.01.01<br>2024.06.20 | 100% |
| 2. | Дэд арга хэмжээ: Хариуцлагын гэрээ, түүний биелэлтийг дээд шатны байгууллагад тайлагнах | Хэрэгжилтийг холбогдох газарт тайлагнасан байдал | Хариуцлагын гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг НЗДТГ-т 2023 оны 1/458, 1/699, 1/1203, 1/1583 дугаар | Төлөвлөгөөний биелэлтийг хугацаанд нь үнэн зөв тайлагнасан байна. | Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, харьяа байгууллагын удирдлагатай байгуулах хариуцлагын гэрээг 2024.01.18-ны өдөр Нийслэлийн Засаг дарга Х.Нямбаатартай Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дарга В.Оюумаа байгуулсан.<br>Гэрээний үүргийн 21 заалтын хэрэгжилтийн хагас жилийн биелэлтийг 2024.06.17-ны өдрийн 1/1092 | 2024.01.01<br>2024.06.25 | 100% |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт / | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | албан бичгүүдээр тус тус тайлагнасан. | | дугаар албан бичгээр болон цахимаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж, хугацаанд тайлагнан ажилласан. | | |
| 3. | Дэд арга хэмжээ: Нэгжийн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг нэгтгэн боловсруулж, тайлагнах | Хэрэгжилтийг тайлагнасан байдал | Нэгжийн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг нэгтгэн, бүрэн хангалттай дүгнүүлсэн. Нэгжийн төлөвлөгөөний хэрэгжилт 93%-тай. | Нийт албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулсан байна. | Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлагдсаны дагуу Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн нэгжийн даргад танилцуулсан.<br>Нийт 5 төрийн захиргааны, 9 төрийн үйлчилгээний албан хаагчдын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах саналаа ирүүлсний дагуу 36 арга хэмжээтэй төлөвлөгөөг 2024.01.22-ны өдөр албажуулан батлуулсан.<br>Мөн Өмчийн менежмент, Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хянаж, холбогдох санал өгсөн. | 2024.01.01<br>2024.02.20 | 100% |
| 4 | Дэд арга хэмжээ: Цаг үеийн шинжтэй төлөвлөгөө, тайлан түүний хэрэгжилтийг хангаж ажиллах | Хэрэгжилтийг тайлагнасан байдал | Ногоон худалдан авалтын тайлан, дүрмээр хүлээсэн чиг үүргийн тайлан, онцлох ажлын тайлан зэргийг цаг үеийн шинжтэй төлөвлөгөө тайлангийн хэрэгжилтийг хангаж ажилласан. | Төлөвлөгөөний хэрэгжилтийг дээд газраас ирүүлсэн хугацаанд үнэн зөв шуурхай тайлагнаж ажилласан байна. | Ерөнхий сайдын 2024 оны 01 дүгээр албан даалгаврын дагуу эрчимжүүлэх ажлын 7 арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан, газрын даргаар 2024.02.01-ний өдөр батлуулсан.<br>- I улирлын хэрэгжилтийг 2024.03.01-ний өдрийн 1/376 дугаар албан бичгээр НЗДТГ-т тайлагнасан.<br>- II улирлын хэрэгжилтийг 2024.06.20-ны 1/1105 дугаар албан бичгээр НЗДТГ-т тус тус тайлагнасан.<br><br>Нийслэлийн Засаг дарга Х.Нямбаатар томилогдсоноос хойших хугацаанд Нийслэлийн Өмчийн харилцааны газраас зохион байгуулсан томоохон ажлын тайланг 2024.01.08-ны өдрийн 1/24 тоот албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. | 2024.01.01<br>2024.12.01 | 100% |

89

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт / | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | Нийслэлийн худалдан авах ажиллагааны газарт ногоон худалдан авалтын судалгааны тайланг 2024 оны 3/480, 1/782, 1/1554 дугээр албан бичиг тус тус хүргүүлсэн.<br><br>Нийслэлийн Өмчийн харилцааны газрын нээлттэй өгөгдөл болгон нийтлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2024.01.30-ны өдөр Газрын даргад танилцуулж батлуулсан.<br><br>Нийслэлийн Засаг даргын 2024 оны 03 дугаар албан даалгаварыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2024.10.03-ны өдөр Газрын даргад танилцуулан батлуулсан. | | |
| 5 | Арга хэмжээ 3.1.10 "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарих | Тарьсан модны тоо Цэнэг усалгаа хийсэн байдал<br>- | 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдөр, 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдрүүдэд Налайх дүүргийн "Шинэ-Налайх" цэцэрлэгт хүрээлэнд 5 шинэс модны суулгасан. | Мод тарих арга хэмжээнд оролцох, тайлагнах | Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Налайх дүүргийн Шинэ-Налайх цэцэрлэгт хүрээлэнд 2 удаа мод тарих арга хэмжээнд байгууллага хамт олноороо оролцсон.<br>- 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдөр 100 ширхэг хайлаас модыг зааврын дагуу тарьж, усалгаа, арчилгаа хийсэн. Тайлан мэдээг 2024.05.14-ний өдрийн 1/868 дугаар албан бичгээр Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Байгаль орчны газарт тус тус тайлагнаж ажилласан.<br>- 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдөр Налайх дүүргийн цэцэрлэгт хүрээлэнд 11 ширхэг миндаль модыг тарьсан.<br>Мөн байгууллагын дотоод сүлжээ болон нийслэлийн ERP сүлжээнд зурган мэдээгээр тус тус байршуулсан. | 2024.01.01<br>2024.10.04 | 100% |

83

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт / | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 6 | Арга хэмжээ 3.1.11 2024 оны "Тохижилт бүтээн байгуулалт"-ын жил төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний дагуу байгууллагын хэмжээнд арга хэмжээ шинээр санаачлан ажиллах | Төлөвлөгөөний хэрэгжилт | Бүх нийтийн их цэвэрлэгээний ажилд тогтмол оролцсон. | Нийслэлийн батлагдсан төлөвлөгөөний дагуу арга хэмжээ төлөвлөн ажилласан байна. | 2024 оныг "Тохижилт-Бүтээн байгуулалтын жил" болгон зарласантай холбогдуулан цэвэрлэгээний арга хэмжээнд оролцсон байдал:<br>- "Хаврын их цэвэрлэгээ" нэгдсэн арга хэмжээнд Сити товер барилгын Ашиглалтын захиргаатай хамтран 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр байгууллагын гадна /Сити товер/ орчны 50 метр хүртэлх талбайн хог хаягдлыг түүж, гадна шат, үүдний хэсэгт хөөстэй угаалга цэвэрлэгээ,<br>- 2024 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан хуваарийн дагуу Чингэлтэй дүүрэгт Баянбүрдийн тойргоос урагшаа Тусгаар тогтнолын талбайн урд үзүүр хүртэлх талбайн явган хүний замын дэргэдэх түүвэр хог хаягдлыг цэвэрлэсэн.<br>Мөн байгууллагын дотоод тохижилтыг шинэчлэн, ажиллах орчноо сайжруулж, өрөө тасалгааны шинэ зохион байгуулалт хийхэд хувь нэмрээ оруулж ажилласан. | 2024.01.01<br>2024.12.01 | 90% |
| Зорилт 4. Байгууллагын гаргасан бодлогын баримт бичгийг тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зорилтын хүрээнд | | | | | | | |
| 7 | Арга хэмжээ: 3.4.1 Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг | Хэрэгжилтийг холбогдох газарт тайлагнасан байдал | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг сар бүр нэгтгэж, холбогдох газарт хүргүүлж ажилласан. | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг нэгтгэж, тайлагнасан байна.<br>2 удаа албан бичгээр | Бодлогын баримт бичиг тайлагнасан байдал:<br>- 2024 оны нийслэлийн хөгжлийн төлөвлөгөөний I улирлын хэрэгжилтийг тайланг 2024 оны 1/670 дугаар албан бичгээр, II, III улирлын тайланг ERP системийн хяналт шинжилгээ үнэлгээний цэсэнд цахимаар байршуулан ажилласан байна.<br>- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн II улирлын тайланг цахимаар Хяналт-шинжилгээ үнэлгээний газарт тайлагнаж ажилласан.<br>Нийт тайлант хугацаанд 277 захирамжлалын баримт бичиг шилжин ирснийг зохих журмын дагуу, хяналтын | 2024.01.01<br>2024.11.08 | 100% |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхлэсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт / | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | нэгтгэж тайлагнах | | | | карт үйлдэн, удирдлагад танилцуулан, хариуцан хэрэгжүүлэх хэлтэс нэгжүүдэд цаасан болон цахим хэлбэрээр шилжүүлсэн. Үүнд:<br>- Засгийн газрын тогтоол бусад шийдвэр – 3<br>- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол – 57<br>- НИТХ-ийн хуралдааны тэмдэглэл – 1<br>- НЗД-ын зөвлөлийн хурлын тэмдэглэл – 1<br>Нийслэлийн Засаг даргын захирамж – 155<br>- Хөрөнгийн хөдөлгөөн – 92<br>- Эрх шилжүүлэх – 121<br>- Захиалагчийн хяналт – 2<br>Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт захирамжлалын баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнасан байдал:<br>- Хууль тогтоомжийн биелэлтийг unelgee.gov.mn сайтад байршуулсан үндсэн чиг үүрэгт хамааралтай заалтын дагуу сар тутам цахимаар Хяналт-шинжилгээ үнэлгээний газарт тайлагнаж ажилласан.<br>- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн тогтоолын I улирлын биелэлтийн тайланг 2024.04.04-ны 1/616 дугаар албан бичгээр, II дугаар улирлын биелэлтийн тайланг 2024.06.11-ний өдрийн 3/1072 дугаар албан бичгээр, III дугаар улирлын тайланг цахимаар 2024.09.10-ны өдөр Хяналт-шинжилгээ үнэлгээний газарт тайлагнаж ажилласан.<br>- Нийслэлийн Засаг даргын захирамжийн биелэлтийг I улирлын биелэлтийн тайланг 2024.04.10-ны өдрийн 1/663 дугаар албан бичгээр, II дугаар | | |
| | | | | | улирлын биелэлтийн тайланг 2024.06.11-ний өдрийн 3/1071 дүгээр албан бичгээр, III дугаар улирлын тайланг 2024.09.10-ны өдөр цахимаар | | |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт / | Эхэлсэн, дуусcан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | Хяналт-шинжилгээ үнэлгээний газарт тайлагнаж ажилласан.<br>- Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлын биелэлтийг II улирлын биелэлтийн тайланг 2024.06.11-ний өдрийн 1/1068 дугаар албан бичгээр, III дугаар улирлын биелэлтийн тайланг цахимаар Хяналт-шинжилгээ үнэлгээний газарт тайлагнаж ажилласан.<br>Тайлант хугацаанд бодлогын баримт бичгийн хэрэгжилт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг хугацаанд нь зохих журмын дагуу тайлагнаж ажилласан. | | |
| Зорилго 4. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна. | | | | | | | |
| Зорилт 1. Төрийн үйлчилгээг ил тод, хурдан шуурхай, чанартай, хүртээмжтэй болгоно. | | | | | | | |
| 8 | Арга хэмжээ: 4.1.4 Нийслэлийн эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан Ublegal.ulaanbaatar.mn цахим хуудаст байгууллагын даргын тушаалуудыг байршуулж мэдээлэх ажлыг зохион байгуулах | Тушаалын тоо | Ublegal.ulaanbaatar.mn цахим хуудаст байгууллагын газрын даргын тушаалуудыг байршуулсан. | Газрын даргын хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой тушаалыг тухай бүр бүртгэсэн байна. | Газрын даргын хариуцлагын гэрээний 3.10 дэх заалтын дагуу байгууллагын даргын шийдвэр, байгууллагын үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх чиглэлээр Ublegal.ulaanbaatar.mn цахим хуудаст 2024 оны "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын хурлаар хэлэлцүүлэн батлуулсан, нийслэлийн өмчийн болон, төсөвт байгууллагуудын хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой 165 газрын даргын А тушаалыг бүртгэн, төрийн байгууллагууд болон олон нийт танилцах боломжоор ханган ажилласан. | 2024.01.01 2024.09.05 | 90% |
| 9 | Дэд арга хэмжээ: Архив албан хэрэг | Нийт албан бичгийн тоо | Нийт 25 ирсэн бичиг зохих журмын дагуу | Албан хэрэг хөтлөлт, стандарт | - Байгууллагын албан бичгийн дотоод сүлжээгээр 2024.12.01-ний өдрийн байдлаар нийт 75 албан бичиг ирснээс 75 хугацаанд нь, 1 хугацаа хэтрүүлэн | 2024.01.01 2024.12.01 | 100% |

86

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт / | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | хөтлөлтийн тухай хууль, холбогдох дүрэм, журам болон стандартыг байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мөрдөн ажиллах | Хугацаа хэтэрсэн албан бичгийн тоо Шийдвэрлэлтийн хувь | хариу өгсөн байна. | ханган албан бичгүүдийг хугацаанд нь шийдвэрлэсэн байна. | шийдвэрлэсэн байна. Албан бичгийн шийдвэрлэлт 99%-тай байна.<br>- Албан хэрэг хөтлөлтийн EDOC системээр 75 албан бичиг төлөвлөн шилжүүлсэн байна.<br>- Газрын даргын 2024 оны архивын баримт хүлээлгэн өгөх 01 дүгээр албан даалгаврын хүрээнд архивын ажилтанд 15 байнга болон түр хадгалагдах баримтыг баримт хүлээлцэх актаар хүлээлгэн өгсөн. | | |
| 10 | Дэд арга хэмжээ: Нийслэлийн дотоод удирдлагын систем UB ERP системийн өргөдөл гомдол шийдвэрлэлт дэд цэсэд бүртгэгдсэн иргэд аж ахуй нэгжээс ирүүлсэн өргөдөл гомдлыг хүлээн авах, судлах, | Өргөдөл гомдолд нэг мөр хариу өгөх Шийдвэрлэлтийн дундаж хугацаа Зөрчил тооцуулахгүй байх | Өргөдөл гомдол 5 шийдвэрлэсэн. | Өргөдөл гомдол хугацаанд нь шийдвэрлэсэн байна. | Тайлант хугацаанд 1 өргөдөл ирснийг хугацаанд нь шийдвэрлэж хариу өгсөн. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2 хоног, 0 цаг 9 минут. | 2024.01.01<br>2024.12.01 | 100% |

89

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт / | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | хугацаанд нь шийдвэрлэх | | | | | | |
| 11 | Дэд арга хэмжээ: Байгууллагаас зохион байгууллагдаж байгаа олон нийтийн арга хэмжээг зохион байгуулах, оролцох | Оролцсон арга хэмжээний тоо | Дээд газраас зохион байгуулсан сургалт, хэлэлцүүлэг, сургалтад 11 удаа хамрагдсан. | Зохион байгуулагдсан арга хэмжээнд оролцсон байна. | Байгууллагын дотоод ажил болон дээд байгууллагаас зохион байгуулагдсан дараах арга хэмжээг зохион байгуулах, болон оролцоог ханган ажилласан байна. Үүнд:<br>- 2024.01.12-ны өдөр Байгууллагын тайлангийн хурал<br>- "Хаврын их цэвэрлэгээ" нэгдсэн арга хэмжээ 2024.04.12-ны өдөр, 2024.04.13-ны өдөр, 2024.05.14 өдөр тус тус зохион байгуулалтыг хийсэн.<br>- Тэрбум мод арга хэмжээний хүрээнд мод тарих, суулгац худалдан авах ажлыг зохион байгуулсан.<br>- Ахмадад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг 2024.02.07-ны Хангарьд ордонд зохион байгуулсан<br>- НЗД-ын захирамжаар хориотой бүсэд орж ирсэн малыг туух ажлыг зохион байгуулсан.<br>- ТӨБЗГ-аас зохион байгуулсан "Төрийн болон орон нутгийн өмчийн харилцааны салбарын нэгдсэн сургалт"<br>- 21 аймгийн өмчийн газрын спорт арга хэмжээ<br>- Хяналт шинжилгээ үнэлгээ хийх арга зүй мэргэшүүлэх гэрчилгээ олгох хөтөлбөрт хамрагдсан.<br>Байгууллагын үйл ажиллагааг сурталчилан таниулах, дээд газраас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг танилцуулах хүрээнд 15 мэдээллийн постер зураг танилцуулга бэлтгэн дотоод сүлжээ болон ханын самбарт тогтмол шинэчлэн байршуулсан. | 2024.01.12<br>2024.11.08 | 100% |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ны биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт / | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Үүрэг даалгавар арга хэмжээ: Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах | Бүтэн жилээр гүйцэтгэлийг тайлагнасан байх тайланг албан бичгээр хүргүүлсэн байх | Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг НЗДТГ-т 2023 оны 1/1583 дугаар албан бичгүүдээр тус тус тайлагнасан. | Төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилт, шалгуур үзүүлэлтийн дагуу хэрэгжүүлэн ажилласан байна. Төлөвлөгөөний биелэлтийг хугацаанд нь үнэн зөв тайлагнасан байна. | Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтийн тайланг 2024.01.08-ны өдөр 1/22 дугаар албан бичгээр НЗДТГ-т хүргүүлсэн. Мөн 2023-2024 оны Стратеги төлөвлөгөөний төсөл, 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг тус тус тайлагнасан.<br><br>Үүний дагуу Нийслэлийн Засаг даргын 2024 оны "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын 2023 оны ажил дүгнэх тухай" А/349 дүгээр захирамжаар "Хангалттай" үнэлгээ авсан. | 2024.01.01<br>2024.01.12 | 100% |
| 2. | Үүрэг даалгавар: 2023 оны байгууллагын үйл ажиллагааны үнэлгээний тайлангийн хуралд бэлтгэх | НЗД-ын 2022 оны А/1106 дугаар захирамжийн 3 дугаар хавсралтын дагуу тайлан мэдээг бэлтгэх | 2022 оны үйл ажиллагааны үнэлгээ "Хангалтгүй" гэсэн үнэлгээ авсан. | 2023 оны үйл ажиллагааны үнэлгээг "Хангалттай" гэсэн үнэлгээгээр үнэлүүлэх | Нийслэлийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 22-ны А/1532 дугаар захирамжаар байгуулагдсан ажил дүгнэх ажлын хэсэг 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн байгууллага дээр ирж ажилласан. Тус ажлын хэсгийн удирдамжийн дагуу үйл ажиллагаатай холбоотой 11 шалгуур үзүүлэлтийн дагуу 32 хавтас материалуудыг бэлтгэн амжилттай тайлагнасан. | 2024.01.01<br>2024.01.12 | 100% |
| 3. | Үүрэг даалгавар: Нийслэлийн шуурхай хурлын үүрэг даалгавар | Биелэлтийг цаг тухай бүрт дээд газарт тайлагнах | - | Биелэлтийг цаг тухай бүрт дээд газарт тайлагнасан байна. | Нийслэлийн удирдах ажилтны шуурхай хурлын үүрэг даалгаврыг хэрэгжилтийг 2024.01.23-аас эхлэн хариуцаж, 21 удаагийн хурлын 89 үүрэг даалгаврын хэрэгжилтийг ERP системийн хяналт шинжилгээ | 2024.01.23<br>2024.11.08 | 100% |

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт / | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | үнэлгээний цэсэнд байршуулан ажилласан байна. | | |
| 4. | Үүрэг даалгавар: Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн тайлан мэдээг хариуцан ажиллаж | 7 хоног, улирал бүр НЗДТГ-т тайлагнах | Сар тутам НЗДТГ-т тайлагнан ажилласан. | 7 хоног, улирал бүр НЗДТГ-т тайлагнах | Өргөдөл, гомдлын улирлын дэлгэрэнгүй тайланг 3 удаа Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тайлагнасан байна:<br>- I улирлын тайланг 2024 оны 1/601 дугаар албан бичгээр хяналт шинжилгээ үнэлгээний илтгэх хуудастай хамт тайлагнасан.<br>- II улирлын тайланг 2024 оны 1/1066 дугаар албан бичгээр тайлагнасан.<br>- III улирлын тайланг 2024 оны 1/1672 дугаар албан бичгээр тайлагнасан.<br>Мөн байгууллагын сайтад үйл ажиллагааны ил тод байдлыг хангах ажлын хүрээнд өргөдөл гомдлын тайланг улирал бүр байршуулсан.<br><br>Байгууллагын өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн 7 хоногийн явцын тайланг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тайлагнасан 30 удаа албан бичгээр тайлагнасан. | 2024.02.29<br>2024.11.08 | 100% |
| 5. | Үүрэг даалгавар: Нийслэл дээр хэрэгжиж байгаа бодлогын баримт бичгүүдэд өгөх саналыг нэгтгэх | Байгууллагын чиг үүрэг нийцсэн байх | - | Байгууллагын чиг үүрэг нийцсэн оновчтой ирэх 2024-2028 онд хэрэгжихүйц зорилтыг нэгтгэн тайлагнасан байна. | Нийслэлийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх 4 үйл ажиллагааны төлөвлөгөөний саналыг нэгтгэн 2024.05.06-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт цахим шуудангаар илгээсэн. | 2024.06.04<br>2024.11.08 | 100% |

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт / | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | Нийслэлийн Засаг даргын 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах 4 арга хэмжээний саналыг 2024.06.14-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт цахим шуудангаар илгээсэн.<br>Засгийн газрын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд 2 зорилтын хрээнд 4 арга хэмжээний саналыг боловсруулан 2024.10.16-ны өдрийн 3/1777 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тайлагнасан. | | |
| 6. | Үүрэг даалгавар: Байгууллагын эзэмшлийн газрыг мэдээллийн санд байгаа нэрийг солиулах | Байгууллагын газрын мэдээлэл e-mongolia цахимд үнэн зөв орсон байх | - | Байгууллагын газрын мэдээлэл emongolia цахимд үнэн зөв орсон байна. | Байгууллагын balансад бүртгэлтэй 30 байршил дахь газрын эзэмшигчийн нэр солиулахаар 2024 оны 1/508 дугаар албан бичгээр Нийслэлийн Газар зохион байгуулалтын албан хүсэлт илгээсний дагуу e-mongolia цахим системд бүртгэл амжилттай засагдаж баталгаажсан. Мөн байгууллагын нэр 2 өөр регистрээр газрын мэдээллийн систем давхцсан бүртгэлийг засуулсан. | 2024.03.01<br>2024.10.10 | 100% |
| 7. | Үүрэг даалгавар: Нийслэлийн Засаг даргын захирамж, НӨХГ-ын даргын тушаалаар | Нийслэлийн Засаг даргын захирамж, НӨХГ-ын даргын тушаалаар | - | Ажлын хэсгийн тайланг нэгтгэн, хянуулсан байна. | Засаг даргын захирамжаар байгуулагдсан нийт 10 ажлын хэсэгт байгууллагын удирдлага албан хаагчид орж ажилласан тухай тушаалын хэрэгжилтийн товч танилцуулгыг газрын даргад 2024.10 | 2024.06.05<br>2024.11.08 | 90% |

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт / | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэл тийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | байгуулагдсан ажлын хэсгийн биелэлтийг нэгтгэх | байгуулагдсан ажлын хэсгийн шийдвэрийн хэрэгжилтийг бүртгэсэн байх, | | | дүгээр сард танилцуулсан. Үүнд 2 ажлын хэсгийн тайланг байгууллагын архивт хүлээлгэн өгсөн, үлдсэн 8 ажлын хэсгийн биелэлтийн тайланг холбогдох удирдлага, албан хаагчид архивт хүлээлгэн өгөөгүй байна. | | |
| 8. | Үүрэг даалгавар: Газрын даргын тушаалаар ажлын хэсэгт орж ажиллах | Ажлын хэсэгт орж ажиллан, хугацаанд нь тайлагнасан байх | - | Ажлын хэсгийн тайланг хугацаанд нь ажлын хэсгийн даргад танилцуулсан байна. | Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн А/245 дугаар тушаалаар томилогдсон 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг нь Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 08 дугаар сарын 12-ны өдөр баталсан "Олон улсын худалдаа, логистикийн төв" ХК-ийн үйл ажиллага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд шалгалт хийх ажлын удирдамжын дагуу 2024 оны 08 дугаар сарын 08-15-ны өдрүүдэд Нийслэлийн Сүхбаатар дүүрэг (Нийслэлийн өмчийн 1-р байр, 801 тоот) болон Сонгино хайрхан дүүрэг 32-р хороо, Бордооны хэсэг "Авто худалдааны цогцолбор"-т "Олон улсын худалдаа, логистикийн төв" ХК-ний одоогийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж ажилласан. Ажлын хэсэг дараах дүгнэлтийг нэгтгэн танилцуулсан.<br>1. Тус газрын түрээсийн судалгаа нь 2018-2021 оны | 2024.08.12<br>2024.08.16 | 100% |
| | | | | | хугацаанд excel файлаар хадгалагдаж байсан нь өмнөх онуудын түрээсийн судалгаа, | | |

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт / | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | гэрээний тоо, төлбөрийн мэдээлэл харагдах боломжгүй байна. 2022 оноос ашиглалтад орсон программд судалгааны датаг оруулвал өмнөх онуудын түрээсийн тоон мэдээлэл судалгаанд хяналт тавихад хялбар болно.<br>2. Компанийн тухай хууль, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 28 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Олон улсын худалдаа, логистикийн төв" ХК-ийн дүрэм, "Олон улсын худалдаа, логистикийн төв" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 09 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Гүйцэтгэх захиралтай байгуулах контракт гэрээ", Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн хөрөнгийн хөдөлгөөн хийдэг бөгөөд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ыг дагаж мөрддөггүй. Иймд тус Компанийн дагаж мөрддөг дүрэм, тогтоол болон | | |
| | | | | | НИТХ-ын журмыг уялдуулан өөрчлөх шаардлагатай гэж үзэж байна. | | |

93

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт / | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | 3. Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланд хүрсэн түвшингийн мөнгөн дүн, хугацаа, хэрэгжилтийн бодит тоон үзүүлэлт өссөн болон буурсан мэдээлэл дутмаг<br>4. Монгол Улсын болон Нийслэлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд тусгагдсан төсөл хөтөлбөрүүдийн ТЭЗҮ хийгдээгүй, хөрөнгө оруулалтын санхүүжилт тухайн төлөвлөгөөт онд төсөвлөгддөг боловч төсвийг буцаан татдаг гэх зэрэг үндэслэлээр хэрэгжилт хангалтгүй байна. Шалгалтын ажлын тайланг архивт баримтаар хүлээлгэн өгөв. | | |
| 9. | Үүрэг даалгавар: Нүхэн гарцад үйл ажиллагаа явуулдаг иргэдтэй 2024 оны түрээсийн гэрээ байгуулах бэлтгэл ажлыг зохион байгуулах | Нүхэн гарцад үйл ажиллагаа явуулж байгаа иргэдийн хүсэлтийг авах, судалгаг шинэчлэх | - | Нүхэн гарцад үйл ажиллагаа явуулж байгаа иргэдийн хүсэлтийг албан хүсэлтийг авсан байна. Түрээслэгчдийн судалгааг шинэчилсэн байна. | Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газраас хүхэн гарцад үйл ажиллагаа явуулдаг 20 иргэний мэдээлэл ирсний дагуу 2024 оны түрээсийн гэрээг яаралтай байгуулахаар түрээслэгч нартай утсаар холбогдон гэрээ байгуулах хүсэлтийг хүлээн авсан. Үүнд 19 иргэнтэй уулзаж, бүртгэлийн мэдээллийг шинэчилсэн.<br>Түрээсийн гэрээ байгуулах хүсэлтээ өгсөн иргэдийн судалгааг Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газарт 2024.11.20-ны өдрийн 3/1993 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | 2024.11.15<br>2024.11.21 | 100% |

94

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт / | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | Гэрээ байгуулах 19 иргэний хүсэлт, хувийн мэдээллийг Захиргаа удирдлагын хэлтэст баримт хүлээлцэх актаар 2024.11.21-ий өдөр хүлээлгэн өгсөн. | | |
| 10. | Үүрэг даалгавар: Таван толгой түлш борлуулах 70 байршил шилжүүлэхтэй холбоотой газрын мэдээллийг нэгтгэн танилцуулах | Нийслэлийн Засаг даргын захирамжаар ирсэн байршил байх Нийслэлийн газрын мэдээллийн санд бүртгэлтэй эсэх | 2024 онд 70 байршил дээрх хийсэн хяналт шалгалтын ажлын тайлан | Газрын мэдээллийг байршлыг нарийвчлан эзэмшигчийн мэдээлэл, нэгж талбарын мэдээллийг гаргасан байна. | Нийслэлийн Өмчийн харилцааны газрын нэр дээр мэдээллийн санд бүртгэлтэй 36 байршил, иргэний нэр дээр бүртгэлтэй 34 байршил байгаа тухай танилцуулга бэлтгэсэн. Мөн газрын төлбөрийн нэхэмжлэх үүссэн 15 байршлын мэдээллийг боловсруулан, 2024.11.21-ний өдөр нэгжийн даргад танилцуулав. | 2024.11.19 2024.11.21 | 100% |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт / | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 1. Дэс түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдана. | Суралцсан кредит цаг | - | 8 кредит цаг | - 2024 оны эхний хагас жилд Ахлах, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн, Шуурхай ажлын биелэлт хариуцсан мэргэжилтнүүдийг ажил үүргийг хавсран гүйцэтгэж байсан учир сургалтад хамрагдах боломжгүй байсан.<br>- Удирдлагын академийн дэс түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2024.09.20-ны өдрөөс эхлэн суралцаж, эхний 4 кредит цагийн хичээлийг амжилттай судалсан. | 2024.01.01 2024.12.01 | 100% |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт / | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 2. | Арга хэмжээ 2. Гадаад хэлний мэдлэгээ дээшлүүлэх, салбарын чиглэлийн ном, судалгааны материал уншиж танилцах | Уншсан ном, тохимол | - | 1 | Англи хэлний ярианы онлайн LCE English сургалтад 2024.06 сард бүртгүүлж, суралцаж төгссөн. Мөн Удирдлагын академийн дэс түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах явцад эдийн засгийн онол, хэрэглээний эдийн засаг судлалын 2 сурах бичиг уншиж судалсан.<br>Бие даан цахимаар Удирдлагын академын сургалтын сайтад байршсан хичээлийг судлан авсан гэрчилгээнүүд:<br>1. Монгол бичгийн хичээл 1, 2, 3<br>2. Жендерийн мэдрэмжтэй харилцаа холбоо<br>3. Ёс зүйн 2 дугаар түвшин<br>4. Жендерийн дүн шинжилгээ ахисан түвшин<br>5. Хяналт шалгалт дүн шинжилгээ хийх арга зүй | 2024.01.01<br>2024.12.01 | 100% |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН .................... (П.ТҮВШИНЖАРГАЛ)

(албан тушаал) (гарын үсэг)

2024.12.02 (огноо)